

**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д дор дурдсан байдлаар нэмэлт оруулсугай:

“5.7. Энэ журмын 5.3-т заасан хязгаарлалтад банкны холбогдох этгээдээс байршуулсан харилцах, хадгаламжийг оруулан тооцохгүй.”

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН